ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/116/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2023 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn<br>Аудитор Ц.Төмөрсүх<br>Утас: 9805-8805, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга..........................................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
   4.1 Ерөнхий зүйл ..........................................................................................................................
   4.2 Материаллаг байдал ..............................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..................................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..................................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ...........................................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..................................................................................
5. Аудитын илрүүлэлт ......................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 260

танай ____________-ны №______________-т

ЧУЛУУНХОРООТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.БОЛОРТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0110?0358

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшниййх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **156,399,719.50** | **43,013,108.19** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,356,319.49 | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 1,356,319.49 | - |
| **3121** | **Төгрөг** | 1,356,319.49 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,356,319.49 | - |
| **33** | **АВЛАГА** | 112,430,000.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 112,430,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 42,613,400.01 | 43,013,108.19 |
| **351** | **Түүхий эд материал** | 13,179,013.59 | 18,145,679.77 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 168,820.00 | 168,820.00 |
| 35130 | Эм боох материал | 13,010,193.59 | 17,976,859.77 |
| **354** | **Хангамжийн материал** | 29,434,386.42 | 24,867,428.42 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,664,386.42 | 24,867,428.42 |
| 35460 | Хүнсний материал | 770,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **651,141,203.75** | **781,390,910.21** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 651,141,203.75 | 781,390,910.21 |
| **392** | **Биет хөрөнгө** | 632,541,203.75 | 762,790,910.21 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 516,482,675.85 | 646,584,675.85 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (28,871,922.45) | (45,703,456.53) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 38,900,000.00 | 38,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (11,001,388.91) | (17,318,055.59) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 87,369,405.56 | 136,618,141.97 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (25,669,492.84) | (41,364,993.96) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,498,257.98 | 49,345,757.98 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,454,606.56) | (22,337,731.51) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 29,118,443.00 | 29,118,443.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,830,167.88) | (11,051,871.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,600,000.00 | 18,600,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,600,000.00 | 18,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **807,540,923.25** | **824,404,018.40** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **77,834,510.31** | **11,070,313.24** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 77,834,510.31 | 11,070,313.24 |
| **413** | **Өглөг** | 77,834,510.31 | 11,070,313.24 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 20,414,807.20 | 11,070,313.24 |
| **4136** | **Бусад өглөг** | 57,419,703.11 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 57,419,703.11 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **729,706,412.94** | **813,333,705.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 729,706,412.94 | 813,333,705.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 253,065,616.37 | 253,065,616.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 18,600,000.00 | 18,600,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 267,404,469.39 | 351,031,761.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 267,404,469.39 | 267,404,469.39 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 83,627,292.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 190,636,327.18 | 190,636,327.18 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **807,540,923.25** | **824,404,018.40** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **967,760,999.12** | **676,465,019.53** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **260,247,129.12** | **241,452,579.53** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 260,247,129.12 | 241,452,579.53 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 260,247,129.12 | 241,452,579.53 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 15,490,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 260,247,129.12 | 225,962,579.53 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **707,513,870.00** | **435,012,440.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 379,409,800.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 379,409,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 297,808,200.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 155,978,200.00 | - |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 112,430,000.00 | |
| 131106 | Төсвийн урамшуулал | 29,400,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,532,400.00 | 28,962,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,532,400.00 | 28,962,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 11,763,470.00 | 406,050,140.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 11,763,470.00 | 406,050,140.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **872,758,950.13** | **592,807,060.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **872,758,950.13** | **592,807,060.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 843,303,781.95 | 592,040,406.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 433,092,635.51 | 295,531,828.68 |
| 210101 | Үндсэн цалин | 421,348,062.51 | 236,790,442.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,744,573.00 | 43,088,611.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 4,851,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 10,801,775.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,406,791.31 | 36,901,739.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,808,101.83 | 27,479,630.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,933,316.00 | 2,307,436.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,347,200.00 | 1,724,547.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 586,800.00 | 222,128.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,731,373.48 | 5,167,997.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,019,231.82 | 25,395,645.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,886,831.82 | 3,053,245.33 |
| 210302 | Түлш, халаалт | 14,132,400.00 | 22,342,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,145,266.90 | 33,677,494.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,470,100.00 | 2,342,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,686,683.00 | 19,692,974.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,200,000.00 | 1,230,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,349,860.00 | 1,647,420.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,076,500.00 | 1,447,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 3,362,123.90 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 7,318,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 267,587,512.88 | 123,508,355.89 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 256,486,786.08 | 112,789,263.64 |
| 210502 | Хоол, хүнс | 11,100,726.80 | 10,550,592.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 168,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 929,000.00 | 4,379,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 929,000.00 | 4,379,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 350,000.00 | 2,066,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 2,066,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 455,830.00 | 16,969,278.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 16,002,490.80 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 25,000.00 | 63,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 85,000.00 | 43,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 17,830.00 | 20,100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 295,000.00 | 570,288.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,317,513.53 | 53,610,363.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,399,390.00 | 4,290,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,918,123.53 | 49,320,363.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,455,168.18 | 766,654.67 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,400,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,400,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 55,168.18 | 766,654.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,168.18 | 766,654.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **95,002,048.99** | **83,657,958.81** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 3,235,293.96 | 30,666.59 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,235,293.96 | 30,666.59 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (3,235,293.96) | (30,666.59) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **91,766,755.03** | **83,627,292.22** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **595,083,870.00** | **562,932,440.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **29,776,821.38** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 29,776,821.38 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 29,776,821.38 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 29,776,821.38 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **595,083,870.00** | **533,155,618.62** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 379,409,800.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 379,409,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 185,378,200.00 | 98,143,178.62 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 155,978,200.00 | 98,143,178.62 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 29,400,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,532,400.00 | 28,962,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,532,400.00 | 28,962,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 11,763,470.00 | 406,050,140.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 11,763,470.00 | 406,050,140.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **593,727,550.51** | **564,288,759.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **593,727,550.51** | **564,288,759.49** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **564,272,382.33** | **563,522,104.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 381,638,878.51 | 342,125,008.68 |
| 210101 | Үндсэн цалин | 261,737,275.99 | 283,383,622.00 |
| 210102 | Нэмэгдэл | 74,160,000.00 | 43,088,611.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,641,312.52 | 4,851,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,100,290.00 | 10,801,775.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,849,425.20 | 38,319,683.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,250,735.72 | 28,897,573.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,933,316.00 | 2,307,436.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,347,200.00 | 1,724,547.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 586,800.00 | 222,128.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,731,373.48 | 5,167,997.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,019,231.82 | 25,395,645.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,886,831.82 | 3,053,245.33 |
| 210302 | Түлш, халаалт | 14,132,400.00 | 22,342,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,467,323.00 | 28,736,114.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,550,100.00 | 4,262,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,206,363.00 | 19,096,094.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,200,000.00 | 1,230,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,349,860.00 | 1,647,420.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,161,000.00 | 2,500,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 72,986,083.80 | 87,964,294.91 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 61,095,807.00 | 74,840,752.66 |
| 210502 | Хоол, хүнс | 10,011,276.80 | 11,555,042.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,879,000.00 | 1,568,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,106,220.00 | 17,655,880.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,648,220.00 | 14,086,380.00 |
| 210604 | Урсгал засвар | 458,000.00 | 3,569,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 350,000.00 | 2,066,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 2,066,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 455,830.00 | 16,969,278.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 16,002,490.80 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 25,000.00 | 63,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 85,000.00 | 43,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 17,830.00 | 20,100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 295,000.00 | 570,288.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,399,390.00 | 4,290,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,399,390.00 | 4,290,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,455,168.18** | **766,654.67** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,400,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,400,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 55,168.18 | 766,654.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,168.18 | 766,654.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,356,319.49** | **(1,356,319.49)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 1,356,319.49 | (1,356,319.49) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 1,356,319.49 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 271,665,616.37 | 190,636,327.18 | 175,637,714.36 | 637,939,657.91 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **271,665,616.37** | **190,636,327.18** | **175,637,714.36** | **637,939,657.91** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 91,766,755.03 | 91,766,755.03 |
| C08 | **2021оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **271,665,616.37** | **190,636,327.18** | **267,404,469.39** | **729,706,412.94** |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **271,665,616.37** | **190,636,327.18** | **267,404,469.39** | **729,706,412.94** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 271,665,616.37 | 190,636,327.18 | 267,404,469.39 | 729,706,412.94 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 83,627,292.22 | 83,627,292.22 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **271,665,616.37** | **190,636,327.18** | **351,031,761.61** | **813,333,705.16** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон | | | /Төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 502,949,600.00 | 465,378,926.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 502,949,600.00 | 465,378,926.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 502,949,600.00 | 465,378,926.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 308,844,100.00 | 286,869,985.68 |
| 210101 | Үндсэн цалин | 201,293,600.00 | 228,128,599.00 |
| 210102 | Нэмэгдэл | 72,896,600.00 | 43,088,611.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,152,600.00 | 4,851,000.00 |
| 210104 | Урамшуулал | 28,501,300.00 | 10,801,775.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,650,200.00 | 35,819,009.68 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,396,900.00 | 26,396,899.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,063,300.00 | 2,307,436.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,450,700.00 | 1,724,547.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 612,600.00 | 222,128.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,126,700.00 | 5,167,997.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,162,300.00 | 25,395,645.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,819,900.00 | 3,053,245.33 |
| 210302 | Түлш, халаалт | 22,342,400.00 | 22,342,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,438,900.00 | 25,946,105.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,342,100.00 | 2,342,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,187,700.00 | 18,748,085.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,230,000.00 | 1,230,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,687,400.00 | 1,647,420.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,991,700.00 | 1,978,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 75,571,900.00 | 64,453,201.71 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 64,253,800.00 | 53,189,109.46 |
| 210502 | Хоол, хүнс | 9,702,700.00 | 9,695,592.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,615,400.00 | 1,568,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,569,500.00 | 3,569,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,569,500.00 | 3,569,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,104,600.00 | 2,066,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,104,600.00 | 2,066,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,241,500.00 | 16,969,278.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,142,000.00 | 16,002,490.80 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 270,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 63,300.00 | 63,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 55,000.00 | 43,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 20,100.00 | 20,100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 658,100.00 | 570,288.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,366,600.00 | 4,290,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,366,600.00 | 4,290,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 502,949,600.00 | 465,378,926.20 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 28,962,300.00 | 28,195,645.33 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 28,962,300.00 | 28,195,645.33 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 31,133,200.00 | 31,133,140.87 |
| 1200010 | Төсөвт байгууллагын өөрийн орлого/туслах/ | 31,133,200.00 | 31,133,140.87 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 442,854,100.00 | 406,050,140.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 442,854,100.00 | 406,050,140.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 1,356,319.49 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **98,143,178.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **98,143,178.62** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 98,143,178.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 55,255,023.00 |
| 210101 | Үндсэн цалин | 55,255,023.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,500,673.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,500,673.42 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,790,009.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,920,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 348,009.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 522,000.00 |

| | | |
|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 23,511,093.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,651,643.20 |
| 210502 | Хоол, хүнс | 1,859,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,086,380.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,086,380.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 98,143,178.62 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 98,143,178.62 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 98,143,178.62 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Эрхэм зорилго: Иргэдийн хүсэл хэрэгцээг хангахуйц, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй үзүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.8 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,356.3 | - | (1,356.3) |
| Авлага | 112,430.0 | - | (112,430.0) |
| Бараа материал | 42,613.4 | 43,013.1 | 399.7 |
| Үндсэн хөрөнгө | 651,141.2 | 781,390.9 | 130,249.7 |
| **Нийт хөрөнгө** | **807,540.9** | **824,404.0** | **16,863.1** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 77,834.5 | 11,070.3 | (66,764.2) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 729,706.4 | 813,333.7 | 83,627.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **807,540.9** | **824,404.0** | **16,863.1** |

Дээрх хүснэгтээс харахад авлага буурсан нь өмнөх оны авлага бүрэн төлөгдсөнтэй холбоотой байна.

Бараа материал данс 0.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 163.9 саяын бараа материал орлогод бүртгэж, 163.6 сая төгрөгийн бараа материал зарлагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 130.2 сая төгрөгөөр өссөн нь 49.4  саяын хөрөнгө орлогод бүртгэж, 130.1 саяын их засвар хийж хөрөнгийн өртгийн нэмэгдүүлж, 1.4 саяын хөрөнгийг акталж, тайланд онд 49.2 сая төгрөгийн элэгдэл тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 813.3 сая төгрөг болж 83.6 сая төгрөгөөр өссөн нь тайланд хугацааны ашигтай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг  улсын төсвөөс  572.1 сая, нийт зарлагыг 572.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг хүргүүлснээр нь 572.1 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 406.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 28.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 29.7 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 392.7 сая төгрөг буюу 92.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах /Ковид19/ авлагын санхүүжилтийг 100071320401 тоот нэмэлт дансанд 98.1 сая төгрөгийг хүлээн авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 592.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус байгууллага нь 2022 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 130.0 сая төгрөгийн гүйлгээг сар бүрээр байршуулах мэдээллийг улирлаар шивж байршуулсан байна.

***Шийдвэрлэсэн нь*:** Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 1 албан шаардлага, 1 төлбөрийн актын хэрэгжилт 100 хувь байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 350.0 | 1 | 350.0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 476,200.0 | 1 | 476,200.0 | 100 |
| **Нийт дүн** | **1** | **476,550.0** | **1** | **476,550.0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илгээгүй байна.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2022 онд шилэн дансны мэдээллийг байршуулахдаа орлогын дүнг мэдүүлээгүй /1сарын дүн/ | 1 | 130,092.7 | | | 1 | 130,092.7 | | |
| | 0 | - | | | | | | |
| Дүн | 1 | 130,092.7 | 0 | - | 1 | 130,092.7 | 0 | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | 0 | - | | | | | | |
| | 0 | - | | | | | | |
| Дүн | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| Нийт дүн | 1 | 130,092.7 | 0 | - | 1 | 130,092.7 | 0 | - |